

“Япон хэлний боловсролын судалгаа” сэтгүүл Япон сан

Дугаар №11 (67-82 х) 2015 он

Индонезийн дунд сургуульд “хичээлийн судалгаа”-г туршсан үр дүн

- Туршилтаас хичээлийн шинэчлэлд –

Иви Лусиана, Хигашида Акико, Үэно Мика

Япон хэлнээс орчуулсан НХУС-ийн ДДХТ-ийн багш Д.Бурмаа

Түлхүүр үг: Индонез, бага дунд боловсрол, хичээлийн судалгаа, хичээлийн шинэчлэл, багшийн хөгжил

Хураангуй:

Индонезийн дунд сургуульд япон хэл суралцагчдын тоо нэмэгдэхийн хэрээр багш бэлтгэх нь тулгамдсан асуудал болоод байна. Япон сангийн Жакарта дах японы соёлын төвөөс дээрх асуудлыг шийдвэрлэхийн тулд олон төрлийн тусламж, дэмжлэг үзүүлсээр ирсэн. Ялангуяа засгийн газартай хамтран зохион байгуулж ирсэн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт ахлах сургуулийн япон хэлний багшийн хөгжилд ихээхэн хувь нэмэрээ оруулсан. Нөгөө талаас тэдгээр сургалтаар хөндөгдөөгүй асуудлууд хийгээд багшийн хөгжлийг тойрсон хэлэлцүүлэг дэх paradigm shift (хувьсал өөрчлөлт)-тэй харьцуулж үзвэл “багшийн хөгжил” –ийг дэмжих шинэ оролдлого үгүйлэгдэж байна. Энэхүү судалгааны өгүүлэлээр тэдгээр авах арга хэмжээний нэг болгож индонезийн дунд, ахлах сургуулийн япон хэлний багш нарын холбоотой хамтран туршсан “хичээлийн судалгаа” –ны талаар танилцуулна. “Хичээлийн судалгаа” хийсний үр дүнд ахлах сургуулийн багш нарын сурч мэдсэн зүйл хийгээд түүний үр дүнд хүрсэн ололт амжилт, тулгамдсан асуудалд түшиглэн дунд сургуулийн япон хэлний сургалтанд “хичээлийн судалгаа” хийх үндэслэл, бэрхшээлтэй асуудлыг судласнаар багшийн хөгжлийн талаарх асуудлыг эрчимжүүлэх боломжтой гэж үзсэн.

1. Туршилтын ерөнхий байдал

2012 оны Япон хэлний сургалт явуулж буй байгууллагын талаарх судалгаа (Япон сан 2013)-наас үзвэл индонез улс япон хэл суралцагчдын тоогоороо дэлхийд 2-рт орж байгаа бөгөөд тэдгээрийн 96 хувийг дунд сургуулийн сурагчид эзэлж байна. Мөн сонгон судлах гадаад хэлний хичээлээр япон хэл суралцах ахлах ангийн сурагчдын тоо нэмэгдсэн. Япон сангийн Жакарта дах японы соёлын төв (цаашид JFJ гэх) суралцагчдын тоо өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан багшийг хөгжүүлэхийн тулд засгийн газартай хамтран ахлах сургуулийн багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт (цаашид хамтран зохион байгуулах сургалт гэх) хийгээд орон нутгийн япон хэлний сургалтын цахим

сүлжээ бий болгох, ашиглахад тусламж дэмжлэг үзүүлсээр ирсэн (Фүжинага, Фүрукава, Эфи 2006, Тори 2007). Хамтран зохион байгуулах сургалт “суурь→үргэлжлэл→дунд шат→дээд шат” гэсэн үе шаттайгаар дизайнчлагдан оролцогчдын заах ур чадвар хийгээд япон хэлний чадварт ахиц гарсан.

Гэвч гаднаас уригдсан багш нар явуулж байсан бөгөөд бодит байдлаас хол туршилт хичээл, төсөлт ажил бүхий сургалтаар том жижиг олон тооны арлын орны тус тусын онцлог, бодит байдлыг нэгтгэх боломжгүй. Мөн мэргэжил дээшлүүлэх сургалтыг тасралтгүй явуулах боломжгүй гэх мэт асуудлууд тулгамдсан хэвээр байна. Чадварлаг япон хэлний багш бэлтгэх үр дүнтэй аргыг эрэлхийлэх хэлэлцүүлэг, санал шүүмжид “багшлах дадлага (дасгал сургуулилтаас)”-аас “багшийн хөгжил”-д чиглэсэн хувьсал өөрчлөлт ажиглагдаж байна (Ёкомизо2000:6).

Тиймээс бид мэргэжил дээшлүүлэх сургалтаар зогсохгүй индонезийн өнөөгийн байдалд тохирох багшийг хөгжүүлэх шинэ аргыг эрэлхийлж индонезийн ахлах, дунд сургуулийн япон хэлний багш нарын холбоо (Asosiasi Guru Bahasa Jepang Indonesia Цаашид: AGBJI)⁽⁴⁾-той хамтран япон хэлний хичээлд “хичээлийн судалгаа” хийж үзлээ.

Энэ өгүүлэлд туршилт явуулснаар оролцогчдын олж авсан ололт амжилт, тулгарсан бэрхшээлийн талаар эхлээд нэг мужийн жишээн дээр дэлгэрэнгүй тайлбарлана. Дараа нь туршилтын эцсийн үр дүнг нэгтгэж индонезийн дунд сургуулийн япон хэлний сургалтанд “хичээлийн судалгаа” хийхийн үндэслэл хийгээд боломжийг судлалаа. Үүнд үндэслээд хичээлийг илүү сайжруулахыг эрэлхийлэх, багшийг хөгжүүлэхэд өчүүхэн хувь нэмэр оруулахыг хичээлээ.

2. Энэхүү судалгааны хүрээнд авч үзэх “хичээлийн судалгаа”

2.1 Индонез дах “хичээлийн судалгаа”

“Lesson study”-г японы жүгё кэнкю буюу “Хичээлийн судалгаа” дэлхийн улс орнуудад түгэн дэлгэрсэн зүйл гэж үздэг. Индонезид 1998 оноос Эдийн засгийг хөгжүүлэх тусламж (ODA)-ийн хүрээнд засгийн газар, японы JICA-тай хамтран “Lesson study” буюу “хичээлийн судалгааг” явуулж ирсэн. 2010 онд боловсролын тухай хуулийн 27-р зүйлд шинэ багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгад “хичээлийн судалгаа”-ны талаарх ойлголтыг багтаана гэж заасан. Мөн “Бүгд найрамдах индонез улсын дунд боловсролын чанарыг сайжруулах төсөл (JICA-Pelita төсөл)”-ийн хүрээнд ЕБС-ийн багшид зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтын агуулгад “хичээлийн судалгаа”-г оруулсан.

JICA-Pelita төсөл нь 2006-2013 онд хэрэгжиж “оролцооны чиг хандлагатай сургуулийн менежмент болон хичээлийн судалгааг хэрэгжүүлэхийн тулд төв болон орон нутгийн боловсролын төрийн захиргааны байгууллагын чадвар нэмэгдэх”-сэнээр дунд боловсролын чанарыг сайжруулахыг зорих болсон.

Өөрөөр хэлбэл оролцооны чиг хандлагатай сургуулийн менежмент болон хичээлийн судалгааг түгээн дэлгэрүүлэх дунд түвшиний төлөвлөгөөний төсөл, зохицуулах чадварыг сайжруулах, орон нутгийн түвшинд чадварыг ахиулах, оролцооны чиг хандлагатай сургуулийн менежмент болон хичээлийн судалгааны үйл ажиллагааг эрчимжүүлэх, бусад бүс нутагт түгээн дэлгэрүүлэхийг үйл ажиллагааныхаа гол багана болгосон. Зорилго хийгээд агуулгаас “оролцооны чиг хандлагатай сургуулийн менежмент”, “хичээлийн судалгаа” өөрөөр хэлбэл “Lesson stady” нь төслийн цөм болохыг мэдэх болно.

JICA-Pelita төслийн багийн мэргэжилтэн (цаашид JICA-гийн мэргэжилтэн гэх) –ний өгүүлснээр уг төсөл нь баруун Ява мужаас аваад Жогжакарта тусгай муж, зүүн Ява, баруун Суматра, өмнөд Калимантан, хойд Сулавеси, Бантэнд хэрэгжсэн. Гол судлагдахуун нь дунд сургуулийн байгалийн ухаан, математикийн хичээлийн туршилт байсан бөгөөд бүс нутгаас хамаараад англи хэл, индонез хэл гэх мэт хичээл, цаашлаад бага сургууль, ахлах сургуулийг ч хамарсан.

Уг төслийн үр дүнд “индонезийн төв суурин, орон нутаг, сургууль гэх мэт бүх шатанд хичээлийн судалгааны ололт амжилтыг тодорхой түвшинд ойлгож хүлээн авсан.” Мөн “хичээлийн судалгаа нь бага, дунд боловсролын чанарыг сайжруулахад чухал үүрэг гүйцэтгэж буй “сурагч төвтэй” сургалтын арга зүйд түшиглэдэг учраас өндрөөр үнэлэгдэж байсан.” Түүнээс гадна “энэ төслөөр хичээлийн судалгаа хийхэд үйл ажиллагааны зардал шаардлагагүй болохыг индонезийн тал талархан хүлээн авсан” гэх мэт амжилтанд хүрсэн.

Танака (2011) агуулга, аргазүй нь олон талтай болохыг онцлоод хичээлийн судалгаа нь нэгд “багш илүү сайн хичээл заахыг зорьж өөрийн чадварыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа”, хоёрт “хичээлийн чанар, үр өгөөжийг нэмэгдүүлэхийг зорьсон багшийн сурч хөгжих орчин” гэж үзээд “боловсролыг шинэчлэхийн тулд хичээлийн судалгаа хийдэг” гэж тодорхойлсон байдаг. Бидний судалгаа энэ үзэл баримтлалыг чиг шугам болгосон.

2.2 Япон хэлний хичээлд туршсан “хичээлийн судалгаа”

“Хичээлийн судалгаа”-ны талаар орон даяар тархаж, ахлах сургуулийн япон хэлний болон бусад хичээлийн багш нар ч туршилтын талаар сонирхон үзэж, сонсохыг эрмэлзэж, сургуулиараа оролцох боломжийг эрэлхийлж эхэлсэн. Ингээд 2012 оны 10-р сард AGBJI нь JFJ-д япон сангийн сакура тусламжийн үйл ажиллагааны хүрээнд “хичээлийн судалгаа” нэртэй сургалт явуулах хүсэлт гаргасан.

AGBJI нь “хичээлийн судалгаа” нэртэй сургалт (цаашид LS сургалт гэх)-ын зорилгыг “хичээлийн судалгааг хамтын тасралтгүй хичээлийн туршилт гэж үзээд энэ үйл ажиллагаагаар хичээлийн чанар, сургалтанд хандах хандлага сайжирч, багшийн мэргэжлийн чадвар, бүтээлч хандлага, шинийг эрэлхийлэх хандлага нэмэгдэнэ” гэж үзсэн. Тухайн үед AGBJI, JFJ хоёрын аль алинд “хичээлийн

судалгаа”-ны талаар туршлагатай боловсон хүчин байхгүй байсан учир дэмжлэг авах, амжилтанд хүргэх, хэрэгжүүлэх боломжийг эрэлхийлэх үүднээс JICA-гийн мэргэжилтэн, ICLS (Индонезийн хичээлийн судалгааны төв)-тэй хамтрах хүсэлт гаргасан.

Үүний үндсэн дээр индонезийн өнөөгийн байдалд хамгийн тохирно гэж үзээд дээр дурдсан Танака (2011)-гийн тодорхойлолтод үндэслэн япон хэлний хичээлд “хичээлийн судалгаа”-ны туршилт хийхээр болсон. “Хичээлийн судалгаа”-г “судалгаанд үндэслэж багшийг хөгжүүлэхийг зорих арга (Инагаки, Сато 1996:187)” гэж ойлгоод, ганцхан ур чадварын туршилт бус багшийг хөгжүүлэх арга зам гэж үзсэн. LS сургалтаар ICLS-ийн багшийн санал, JFJ-ийн хэлэлцүүлэг, AGBJI-ийн саналд тулгуурлан онол, аргазүйн лекц болон индонезийн боловсролын их сургуулийн харъяа ахлах, дунд сургуулийн япон хэлний хичээлийг судлагдахуун болгосон “хичээлийн судалгаа”-нд төвлөрч дизайнчлагдсан. 3 өдрийн LS сургалтын хөтөлбөрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгт 1 LS сургалтын хөтөлбөр

Өдөр	Үдээс өмнө	Үдээс хойш	Орой
1	(ICLS-ийн багшийн лекц) “хичээлийн судалгаа” гэж юу вэ?	(ахлах сургуулийн багш нарын холбооны төлөөлөлийн лекц) Мужуудын урьдчилсан туршилт	<ul style="list-style-type: none"> Нээлттэй хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг хийх арга Нэгж хичээлийн хөтөлбөрийн судалгаа (PLAN)
2	Ахлах, дунд сургуулийн япон хэлний нээлттэй хичээл (DO)	Хэлэлцүүлэг (SEE)+хичээлийг сайжруулахын тулд нэгж хичээлийн хөтөлбөрийг дахин хэлэлцэх	
3	(Муж тус бүрийн ахлах сургуулийн япон хэлний багш нарын холбоо) “хичээлийн судалгаа”-г турших төлөвлөгөө, илтгэл, хэлэлцүүлэг → дүгнэлт		-

Дээрх хүснэгтийн 1 дэх өдрийн үдээс хойш хийгдсэн мужуудын урьдчилсан туршилт нь AGBJI-гаас гаргасан төслөөс LS сургалт явагдах хүртэлх хугацааг тооцож, сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд JFJ-д хэлэлцүүлсэн үйл ажиллагаа бөгөөд ICLS-ийн багш нар, JICA-гийн мэргэжилтэний дэмжлэгтэйгээр туршилтийг явуулсан. Тус өгүүлэл нь дээрх туршилтанд тулгуурласан бөгөөд цаашид “япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”” гэж нэрлэнэ.

3. Япон хэлний хичээлд хийгдсэн “хичээлийн судалгаа”-ны туршилт

Юуны өмнө AGBJI, мужийн ахлах сургуулийн япон хэлний багш нарын холбоо (цаашид MGMP гэх) хоёрын харилцааг тодорхой болгоё. Учир нь LS сургалтыг хэрэгжүүлэгч байгууллага нь AGBJI, харин тус өгүүлэлээр тайлагнах

туршилт нь JFJ болон мужуудын MGMP-гээс LS сургалтын өмнөх үйл ажиллагаа болгож явуулсан.

AGBJI нь индонезийн дунд боловсролын япон хэлний багш нарын холбоо хэмээх байгууллага юм. Индонезид 33 муж байдаг хэдий ч бүх мужид MGMP байдаг гэсэн үг биш. AGBJI нь нийт 20 мужийн MGMP-г гишүүнээр элсүүлсэн байгууллага бөгөөд жил бүр улсын хэмжээний сургалт зохион байгуулж тэдгээрийн төлөөлийг оролцуулдаг. 20 мужаас 7 мужийн MGMP нь JFJ дунд боловсрол хариуцсан япон хэлний мэргэжилтэн (цаашид JF мэргэжилтэн гэх) - тэй, JF мэргэжилтэн юмуу JFJ-ийн индонез үндсэн багш (цаашид үндсэн багш гэх) тогтсон хугацаанд айлчилж байдаг. Энэ удаагийн туршилт өмнө нь япон хэлний хичээлд “хичээлийн судалгаа” хийгдсэн бүс нутгийг хасаад 6 муж (хойд Сулавэси, хойд Суматра, баруун Суматра, дунд Ява, Жогжакарта тусгай муж, Бали)-ийн MGMP-гөөс оролцох санал авсаны үндсэн дээр хэрэгжсэн.

3.1 Туршилтанд оролцогч

Туршилтанд оролцогчдыг мужийн MGMP-гээр сонгуулсан. Ингэхдээ JFJ-д “мужийн MGMP-гийн гишүүн 3-10 хүнтэй баг бүрдүүлж, хамгийн цөөндөө 4 удаагийн туршилтанд хариуцлагатай оролцох хүн сонгох” хүсэлт тавьсан. Үүний үр дүнд хойд Сулавэсигээс 5, хойд Суматрагаас 9, баруун Суматрагаас 10, дунд Явагаас 8, Жогжакарта тусгай мужаас 10, Баригаас 10 түүн дээр AGBJI-гийн төвөөс 2 хүн нийт 54 хүн оролцсон.

3.2 Туршилтын зорилго

Дээр дурдсанчлан бид “хичээлийн судалгаа”-г багшийг хөгжүүлэх шинэ арга гээд “багш нарын хамтын ажиллагаа, хичээлийн шинэчлэлийг тасралтгүй явуулсанаар орон нутгийн ахлах сургуулийн багшийн бие даан хөгжихөд түлхэц болж, багшийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа” гэж үзсэн.

“Хичээлийн судалгаа” нь “Бүх оролцогчидод сонирхолтой байх” нь хамгийн чухал бөгөөд хичээлийг шинэчилж, сайжруулахын тулд хийж буй оролдлого юм. Багш, сурагчийн хэн хэнд нь үр дүнгээ өгөх үйл ажиллагаа болгохыг зорьж, JICA-Pelita төслийн ач холбогдол, үргэлжлэх боломж зэргийг харгалзан туршилтаа давтамжтай явуулсан. Бид математикийн хичээлд оролцогчдоос “хичээлийн судалгаа” нь “багшийн хөгжил”-д тодорхой үр дүн өгсөн болохыг сонсоод япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”-ны зорилго, хүсэлт, бүтэц зэргээ JICA-Pelita төсөлд түшиглэж гаргасан.

Тэгээд япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”-ны зорилгоо “маргаашийн хичээлийг сайжруулах явдал” гэж үзээд, 1-рт багш, сурагчийн хэн хэн нь сурах баяр хөөрийг мэдрэх үйл ажиллагаа болгох, 2-рт сурагч бүрт чанартай япон хэлний хичээл хийх боломж олгох эхний алхам болгох, 3-рт сурагчдийн сурсан зүйлээс заасан хичээлдээ дүгнэлт хийхийг зорилтоо болгосон. Түүний дээр бүх оролцогчид ижил байр сууринаас санал солилцох,

шинэ санаа дэвшүүлэх, сурагчдын байр суурийг ухамсарлах, хичээлийн хариуцлагыг оролцогч бүр хүлээх гэсэн дүрэм баталсан. Үүнийг өмнөх төслөөс суралцсан бөгөөд ирээдүйн MGMP-гийн байдлыг харгалзсаны үндсэн дээр оролцогчид санал нэгтэй дэмжсэн.

Тус туршилт орон нутгийн сургуульд түшиглэн явагдсан. Энэ удаагийн туршилт нь оролцогчид өөр өөрийн онцлог хийгээд бодит нөхцөл байдлаа харилцан ойлгож, тасралтгүй, харилцан хамтарч явуулах туршилт юм. Өмнө явуулж байсан мэргэжил дээшлүүлэх сургалт нь япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, чанар үр өгөөжийг нэмэгдүүлэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэсэн боловч үлдэж орхигдсон асуудлууд ч олон байсан. Тэдгээр асуудалтай нүүр тулж, багшийн хөгжил, багшийн тогтвортой ажиллах боломжийг эрэлхийлсэнд энэ туршилтын мөн чанар оршино.

3.3 Туршилтын явц


Тус туршилт нь 4 удаагийн “хичээлийн судалгаа”-наас бүрдэнэ. 1, 3 дах удаагийн туршилтанд JF-ийн мэргэжилтэн, үндсэн багш оролцсон. Гэхдээ ерөнхийдөө MGMP-ийн удирдлаган дор явуулахыг эрмэлзсэн.

Туршилт явуулахын өмнө оролцогчдод ICLS-ийн материал уншиж судлахыг даалгасан. Мөн анхны удаа JF-ийн мэргэжилтэн, үндсэн багш нар “хичээлийн судалгаа”-ны талаар 2 цагийн танилцуулга хийсэн. Тус танилцуулгад энэ удаагийн туршилт AGBJI-гээс зохион байгуулж буй LS сургалтын бэлтгэл үйл ажиллагаа болох, JICA-Pelita төслөөс индонезийн “хичээлийн судалгаа”-ны товч тайлбар, судалгааны багийнхны сурч мэдсэн зүйл, япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”-ны зорилго, дагаж мөрдөх дүрэм зэргийг тайлбарласнаар бүх оролцогчид ижил мэдээлэлтэй болсон.

Түүний дараа 1 дэх удаагийн “хичээлийн судалгаа”-г явуулж, 2 дах удаагийн туршилтыг JF-ийн мэргэжилтэн байхгүй бүс нутагт явуулсан. Ингэхдээ туршилтын өмнө бас дараа MGMP-гийн даргатай утсаар ярьж зарим нэг заавар өгсөний үндсэн дээр “хичээлийн судалгаа”-г оролцогчид өөрсдөө явуулсан. JF-ийн мэргэжилтэн, үндсэн багш нар 6 мужийн эхний 2 удаагийн туршилтын үр дүн, ололт амжилт, алдаа дутагдалыг нэгтгээд 1-2 цагийн сургалт явуулсаны дараа 3 дах удаагийн туршилтыг явуулсан. 4 дэх удаагийн туршилтыг 2 дах удаагийн туршилттай адилхан зарим бүс нутгийг үлдээгээд MGMP-д даатгаж явуулсан.

LS сургалтын дараа багш нар бие даан, тасралтгүй “хичээлийн судалгаа” хийхэд анхаарч 4 удаагийн туршилт хийхээр зохион байгуулсан.

Туршилт мужуудад 2013 оны 1 сарын сүүлээс 2 сарын эхэнд эхэлж, сард 1 удаа “хичээлийн судалгаа” хийхээр төлөвлөгдсөн боловч зарим мужид сургуулийн үйл ажиллагаа, шалгалт гэх мэт шалтгаанаар 2 удаа хийсэн сар байсан.



3.4 “Хичээлийн судалгаа”-ны бүтэц

Дээрх хүснэгтэнд үзүүлсэнээр энэ туршилтаар 1 удаагийн “хичээлийн судалгаа”-г индонезид нилээн түгээд байгаа “Plan”, “Do”, “See” (Танака 2011:310) гэсэн 3 үе шаттай бүтэцээр, оролцогчидын харъяалагдаж буй сургуулийн үйл ажиллагаа, хичээлийн цагт нийцүүлж 2 өдөр явуулсан.

1 дэх өдрийн “Plan”-ээр “Do”-ийн үед хичээл заах багш бусад оролцогчдийг сурагчийн дүрд тоглуулж туршилт хичээл заана. Хичээлийн зорилгоо нягталж, сурагчийн дүр тоглож буй оролцогчид тэдний байр суурийг ухамсарласны үндсэн дээр сурагч болж “тайлбар ойлгомжгүй байсан”, “өөрөө толгойгоо ажиллуулахгүй, зөвхөн багшийн тайлбар сонсож байна” гэх мэтээр саналаа хэлнэ. Хөтлөгч “Яагаад ингэж бодох болсон” гэдгийг оролцогчдоос асууж, “Хэрхэн өөрчлөх боломжтой болох”-ыг асуух гэх мэтээр хэлэлцүүлэг өрнүүлнэ. Хэлэлцүүлгийн дараа бүх оролцогчид хамтарч хэрэглэгдэхүүн бэлтгэнэ.

2 дах өдөр эхлээд “Do” болох нээлттэй хичээл явуулна. Хичээл заах багш “Plan”-ны хэлэлцүүлэгт тулгуурлан өөрийн эцсийн шийдвэрийг гаргаж сэдэлжүүлэлт, дасгал даалгаварыг сонгон хичээл зааж харин бусад оролцогчид хичээлийг ажиглана. Ингэхдээ “Хэн, ямар үед мэдлэг олж авав, ямар үед мэдлэг олж авч чадсангүй вэ, яагаад?” гэдэгт анхаарлаа хандуулна. Хичээл заах багшийн хариуцсан ангид хийгдэх бөгөөд сурагчдад тусгайлан тайлбар хийхгүй.

“Do”-гийн дараа шууд “See”-г явуулж, хичээлийн талаар хэлэлцэж, хичээлд дүн шинжилгээ хийнэ. Эхлээд хичээл заасан багш сэтгэгдэлээ хэлсэний дараа оролцогчид анзаарсан, эргэлзсэн зүйлээ хэлнэ.

4. Дунд Ява мужид туршсан туршилтын ололт амжилт, тулгарсан бэрхшээл

“Хичээлийн судалгаа” нь тухайн бүс нутгийн онцлог, бодит нөхцөл байдлын талаар нэгдсэн нэг ойлголттой болж, харилцан хамтарч явуулах туршилт юм. Дунд Ява мужийг жишээ татан энэ удаагийн туршилтын ололт амжилт, тулгарсан бэрхшээлийг тайлбарлая.

Энэ мужид JF-ийн мэргэжилтэн байдаг бөгөөд 4 удаагийн туршилтанд бүгдэд нь оролцсон. Мөн энэ удаагийн туршилтаас өмнө хийж байсан тэмдэглэл байсан зэрэг нь ололт амжилт, тулгарсан бэрхшээлийг нэгтгэн дүгнэхэд дөхөмтэй гэж үзээд Дунд Ява мужийг сонгосон. Дунд Ява мужийн MGMP-гийн гишүүд багш нарын холбооноос зохион байгуулж буй үйл ажиллагаанаас гадна хоорондоо хүнлэг, найрсаг харилцаатай боловч ахмад багш нартаа хэт анхаарал тавьж байгаагаас ч юмуу залуу багш нар нь туршлагатай багш нарт саналаа огт хэлдэггүй онцлогтой. Өмнө нь мэргэжил дээшлүүлэх сургалтыг сургагч багш хичээл заасан багшийн аргазүйг шүүмжилж, үнэлэх талбар гэж үзэх багш нар олон байсан бөгөөд “мэргэжил дээшлүүлэх сургалтын явцад хичээл заах”-ыг “бусдаар шүүмжлүүлэх бай болдог” гэж үзэх хандлага ч байсан. Тиймээс залуу багш нар наанаа хүндэлж байгаа дүр эсгэх боловч дотно харилцаа тогтоохгүй байв. Ийм байдалтай байсан Дунд Ява мужийн онцлог, нөхцөл байдалд өөрийн санаачилгаар мэргэжлээ дээшлүүлэх аргыг туршсан энэ удаагийн туршилт ямар мөн чанартай байсныг доор өгүүлнэ.

4.1 Оролцогчдын танилцуулга

Дунд Ява муж дах туршилт 8 хүний бүрэлдэхүүнтэй явагдсан. Бараг бүх багш бусад хичээлд “хичээлийн судалгаа” хийгдэж байгаа талаар мэдэж байсан бөгөөд хэд хэдэн багш 4 жилийн өмнө Сумаран хотын MGMP-гээс зохион байгуулсан “хичээлийн судалгаа” сургалтанд суусан байв. 1 ахмад багш, харин бусад багш нарын ажилласан жил ойролцоо, дийлэнх нь 25-35 насны залуу багш нар байлаа. Оролцогчдыг доор танилцууля.

Хүснэгт 2 Дунд Ява муж дах туршилтанд оролцогчдын танилцуулга

Нэр	Нас	Хүйс	Харъяа сургууль	Япон хэл заасан жил
A	44	эр	Улсын ердийн ахлах сургууль	10-аас дээш жил
B	34	эр	Улсын ердийн ахлах сургууль	6-10
C	26	эр	Улсын ердийн ахлах сургууль	3-6
D	29	эр	Улсын шашны ахлах сургууль	3-6
E	26	эм	Хувийн ердийн ахлах сургууль	3-6
F	25	эм	Улсын ердийн ахлах сургууль	3 хүртэл
G	32	эм	Хувийн ердийн ахлах сургууль	3-6
H	25	эм	Улсын ердийн ахлах сургууль	3-6

4.2 Туршилтын төлөвлөлт

Дунд Ява муж дах туршилт 2013 оны 2 сараас 5 сар хүртэлх хугацаанд 4 удаа хийгдсэн. Төлөвлөлтийг хүснэгт 3-аар үзүүлэв.

Хүснэгт 3 Дунд Ява муж дах туршилтын төлөвлөгөө

Хугацаа	Байр	Анги	Заасан багш	Ажиглагчийн тоо
2013.02	Улсын ердийн ахлах сургууль	10-р анги 39 сурагч	Н	8
2013.03	Улсын ердийн ахлах сургууль	10-р анги 37 сурагч	С	7
2013.04	Хувийн ердийн ахлах сургууль	10-р анги 26 сурагч	Е	8
2013.04	Улсын шашны ахлах сургууль	11-р анги 35 сурагч	Д	7

4.3 D багшийн ололт

Туршилтын эцэст эрс өөрчлөгдсөн D багшид анхаарлаа хандуулая. Туршилтын явцын тэмдэглэл, тайлан, бидний тасралтгүй хийсэн хичээлийн ажиглалт, эргэх холбоо, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, багш нарын холбооны үйл ажиллагаа гэх мэт залгамж холбоо бүхий үйл ажиллагааны үр дүнд D багшид гарсан өөрчлөлтийн талаар дэлгэрэнгүй тайлбарлана. Доор өгүүлэх агуулга нь бидний энэ удаагийн туршилтаас өмнө хийсэн хичээлийн тэмдэглэл (2011.09.09, 2011.10.11, 2013.02.19) хийгээд энэ удаагийн туршилтын явцад хийсэн тэмдэглэл (2013.05.20 “Plan”, 05.21 “Do”, “See” дээр ярьсан зүйл, оролцогчдын дунд өрнөсөн яриа зэрэг багтана) –д хийсэн задлан шинжилгээ болно.

4.3.1 Туршилтад оролцохын өмнөх D багш

Багш D нь 2006 онд их сургуулийн япон хэлний анги төгсөөд 2009 оноос одоо ажиллаж буй сургуульдаа япон хэл зааж байгаа. Цагаар багшилдаг бөгөөд 1-3-р ангийн бүх бүлэгт долоо хоногт 1 цаг (45 минут) нийт 17 цаг зааж буй. 2004 онд япон хэлний түвшин тогтоох шалгалтын 3-р түвшинд тэнцсэн. Японд сурсан, мэргэжил дээшлүүлсэн туршлага байхгүй. Сар бүр зохиогддог Сумаран хотын багш нарын уулзалтанд байнга оролцдог, идэвхтэй багш.

Бид анх 2011 оны 9-р сард D багшийн хичээлд ажиглалт хийсэн. 「～たい」 дүрмийг ашиглан өөрийн хийхийг хүсэж буй зүйлээ бусдад дамжуулах, найзынхаа хийхийг хүсэж буй зүйлийг асууж чаддаг болох гэсэн зорилготой хичээл байв. Өмнөх цагийн агуулгад түшиглэн өөрийн зохиосон харилцан яриа ашиглан ярих дасгал явуулсан боловч шинэ үг, дүрмийг нягтлахгүй, тарааж өгсөн загвар болох харилцан яриаг дахин дахин давтуулсаар хичээл дуусав. Сурагчид нөгөө л харилцан яриаг хэдэн арван удаа чангаар уншсаар залхаж,

хичээл дуусахад хуруу дарам цөөхөн сурагч хичээлд оролцож, бататгах дасгалын үед хэдхэн сурагч цээжилсэн загвар харилцан яриагаа самбарын урд гарч илтгэсэн хэдий ч тэдний дотор цээжилсэн сурагч цөөхөн байв.

Хичээлийн дараа багш D сурагчдын талаар “Үдээс хойш орж буй хичээл учраас хүүхдүүд ядарсан байсан. Мөн өнгөрсөн долоо хоногт үзсэн агуулгаа мартаад харилцан ярианд оролцоогүй сурагч ч байлаа” гэж ярьсан боловч өөрийн заах аргын талаар тайлбар хийгээгүй. Дараа нь бидэнтэй үйл ажиллагааны зорилгоо нягталж, өөрчилж, сайжруулах зүйлийн талаар зөвлөв. Түүнээс хойш D багшийн байдлыг ажиглахаар дараа сард түүний хичээлд дахин ажиглалт хийсэн. Гэвч өмнө өгсөн зөвлөгөө ул мөргүй алга болж багш D-гийн хичээлд шинэчлэл ч, өөрчлөлт ч харагдаагүй.

Тухайн жилийн 12 сар D багш G багштай хөдөөгийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж, А, В багш нар тус сургалтын сургагчаар ажилласан. D багшид хичээл зүтгэл ажиглагдаж, сургалтанд хамрагдсан бусад багш нартай дадлагын хичээл заах дасгалд идэвхи чармайлттай оролцож байсан боловч, сургалтын явцад сурч мэдсэн зүйл өөрийнх нь заасан хичээлд огт тусаагүй байсан. Сургагч багш нарын хэлэлцүүлгийн үед ч түүний талаар сургалтанд идэвхи чармайлттай оролцсон боловч сурч мэдсэн зүйлээ хичээл заахдаа ашиглаж чадахгүй байсан гэж дүгнэсэн. Бид дунд Ява мужид туршилт эхлэхийн өмнөхөн 2013 оны 2 сард дахин түүний хичээлд ажиглалт хийсэн боловч харамсалтай нь хичээлд сургалтын үр дүн огт ажиглагдаагүй.

4.3.2 Туршилтын явц дах D багш

Дунд Ява мужид туршилт эхлээд оролцож буй багш нарын дунд идэвхитэй хэлэлцүүлэх өрнөсөн ч D багш өөрийн санаа бодлоо огт хэлэхгүй, зөвхөн бусдыг сонсож байлаа. Тэдгээр багш нартай санал нийлж байгаа юмуу. “Энэ сурагч хичээлд анхаарлаа хандуулаагүй” гэх мэтээр бодит байдлын талаар хөндөх төдий, өөрийн санаа бодлыг огт хуваалцахгүй байв. 4 дэх удаагийн туршилтын үед хичээл заахаар төлөвлөж байсан багш боломжгүй болж оронд нь D багш заахаар болов. Эхлээд хөдөөгийн багш нарын сургалтын үед нилээдгүй шүүмжлэлд өртсөн зэргээс болж D багшаар хичээл заалгахгүй гэх хүн байсан боловч А багш япон хэлний хичээлд хийх “хичээлийн судалгаа”-гаар багшийн заах аргыг үнэлэх бус сурагчийн сурах үйлд анхаарлаа хандуулж, сурах үйл явцыг таамаглан, өөрийн хичээлд дүн шинжилгээ хийж сайжруулах ёстой гэх мэтээр сэнхрүүлэн ойлгуулсан учир хүлээж авсан.

“Plan”-ны хэлэлцүүлгээр хичээлийн зорилгыг “өөрийн хийж чадах, чадахгүй зүйлийг харилцагч этгээдэд дамжуулж, харилцагчийнхаа хийж чадах, чадахгүй зүйлийг асууж чаддаг болох. Юу хийж чаддаг тухай асууж, хариулж чаддаг болох” хэмээн тодорхойлов.

“Plan”-ны үед D багш хэрхэн явуулахаа мэдэхгүй зогсох бүрд бусад оролцогчид өөр өөрсдийн туршлагадаа тулгуурлан санаа оноо дэвшүүлж D багшид бодох боломжийг бий болгосон. 35 сурагчтай ангид 45 минутын хичээлээр 10 шинэ үг заах төлөвлөгөөтэй байв. Гэвч D багш тус ангийн онцлогийг маш хөдөлгөөнтэй, төвлөрөх чадвар муутай анги гэж тайлбарласан учир A багш сурагчдын сонирхолыг харгалзаж, хичээлийн цагт нийцүүлэн шинэ үгээ дахин сонговол ямар вэ? гэсэн санал дэвшүүлэв. Мөн сурах бичигт гадаад хэлний шинэ мэдлэг олгохдоо тухайн орны үсгээр бичигдсэн зүйлийг хэрэглэж байсан боловч үсэгнээс биш төрийн далбааг сонгож ашиглах нь сурагчдад илүү ойлгомжтой байх болно гэсэн санал ч гарав. “Үсэг ашиглавал сурагчид юу гэж бичсэнийг сонирхож үймэлдэн гадаад хэлэнд анхаарлыг нь хандуулахад бэрхшээл үүсэж болзошгүй тул хичээлд төрийн далбаа ашигладаг” гэсэн багш ч байв.

Тэдгээр саналыг сонссоны үндсэн дээр D багш хэрэглээний давтамж багатай бүжигтэй холбоотой үгийг хасаж, сурагчдын сонирхолд нийцэх магадлал өндөртэй хөл бөмбөг, агаарын теннис гэх мэт өмнө үзсэн үгийг нэмэхээр болов. Мөн гадаад хэлийг заахдаа төрийн далбаа ашиглахаар болов. Өнөөг хүртэл бусдын хэлсэнтэй санал нийлж байна гэх төдийхнөөр хязгаарлаж өөрийн саналаа огт дэвшүүлэхгүй байсан D багш анх удаа өөрийн саналаа үндэслэлтэйгээх бусад оролцогчдод тайлбарлаж харилцан ойлголцсоны үндсэн дээр бусдын саналыг хүлээн авав. Бусад оролцогчдын дунд туршилт эхлэх үед өөрийн зөв гэж бодсон зүйлээ хичээл заах багшид тулгах хүн байсан боловч энэ өдөр тийм хандлага ажиглагдаагүй.

“Do”-гээр D багш өөрийн хэмжээнд “Plan”-аар ярьсан зүйлийг өөрийн болгож хичээлээ заав. Өмнө нь сурагчдын байр байдлыг огт анзаарахгүй хичээлээ үргэлжлүүлэх хандлагатай байсан бол энэ өдөр шинэ дүрэм давтах дасгалын үед ч сурагчдын хариу үйлдлийг харгалзаж, хэцүү санагдсан үед тэднийг хүлээх, цаг зарцуулах гэх мэтээр сурагчдыг ойлгохыг эрмэлзэх хандлага ажиглагдсан.

“See”-гийн үед D багш “Өнөөдрийг хүртэл заалгасан аргаа турших ёстой гэх бодож байсан хэдий ч биеэ барьж сандраад хичээлдээ хэрэгжүүлж чадахгүй байсан. Гэвч “Plan”-ны үед бусад оролцогчидтой хамтарч үйл ажиллагаа бүрийг нэг бүрчлэн нягталж, тэдгээр үйл ажиллагаа тус бүрийн зорилго, аргазүйн талаар сайтар ярилцсаны үр дүнд хичээлийг хэрхэн явуулах вэ гэдгийг бага багаар бодож тунгааж чаддаг болсон” гэж дүгнэсэн.

4.3.3 D багшид гарсан өөрчлөлт

“See”-гийн үед хөдөөгийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтанд сууж байсан D багшийг сайн мэдэх B багш “хичээлийн явцыг сайтар ойлгож, сурагчдын байдлыг анзаарч, хичээлээ зааж буй D багшид гарсан өөрчлөлт намайг гайхуулж чадлаа” хэмээн өгүүлэв. D багштай хамт сургалтанд суусан G

багш “хэлэлцүүлэг хийж бүгдээрээ хамтдаа хичээлийг төлөвлөж байхдаа D багшийн аргазүйд өөрчлөлт гарч байгааг анзаарсан” хэмээн сэтгэгдлээ хэлэв.

D багш ч өөрөө сурагчдын ойлголт, нөхцөл байдалд нийцүүлэн авах арга хэмжээний талаар “урьд нь огт бодож байгаагүй зүйлүүдийг “Plan”-ийн үед бодсон болохоор эргэлзэхгүй зааж чадсан” хэмээн сэтгэгдлээ хэлэв. Мөн сурвалжлага авах үйл ажиллагааны үед сурагчид япон хэлээ ашиглахгүй сурвалжлагын хуудсаа бие биендээ үзүүлээд төрөлх хэлээрээ ярьж байсан гэв. Иймд сурагчдыг япон хэлээ ашиглаж чаддаг болгохын тулд хэрхэн өөрчлөх талаар ярилцаж байх үед D багш “хэдэн найзаасаа сурвалжлага авч чадах вэ туршиж үзэцгээе” гэсэн өөрийнхөө тайлбарт асуудал байгаа юм болов уу гээд бусад багш нарын саналыг чих тавин сонсов. B багш “D багшийн тайлбарыг сонсоод хүүхдүүд аль болох олон хүнээс сурвалжлага авах ёстой хэмээн ойлгоод найзтайгаа япон хэлээр харилцан ярих бус, сурвалжлагаа хурдан дуусгахыг хичээсэн байх” гэсэн өөрийн бодлыг хэлэв. D багш “Дараагийн удаа сурагчдыг яаруулах тайлбар хийлгүй цөөн хүнээс сурвалжлага авч болох учраас аль болох бүх асуултандаа хариулт авах байдлаар тайлбар хиймээр байна” гэсэн өөрийн саналаа хэлэв.

Хичээл заах багшийн хувьд “Plan”, “Do”, “See”-ийг дуусгаад D багш “Одоогоор ангийг бүхэлд нь хянаж чадахгүй байгаа боловч сурагчдад маш сонирхолтой байх шиг санагдсан. 2009 оноос энэ сургуульд багшилсан хэдий ч өнөөдрийнх шиг хөөрч баярласан сурагчдыг анх удаа харлаа. Багш өөрөө оролдож, бодож боловсруулж хичээлээ сайжруулбал сурагчид ч өөрчлөгдөх юм байна гэдгийг мэдэрлээ. Үнэхээр сайхан байлаа.” хэмээн яриу. Эндээс D багш сурагчдын хариу үйлдэлд тулгуурлаад өөрийн заах аргыг эргэж харах, түүнийгээ хичээлийн шинэчлэлтэй холбоход суралцаж, энэ нь цаашлаад сурагчдад нөлөөлдөг болохыг ойлгосон хэмээн дүгнэх боломжтой.

4.4 Дунд Ява мужийн ололт амжилт, тулгарсан бэрхшээл

Дээр дурдсанчилан өнөөг хүртэл дунд Ява мужийн залуу багш нар ахмад туршлагатай багш нарт саналаа хэлэхгүй байх хандлагатай байсан боловч энэ удаагийн туршилтын явцад ажилласан жилээс үл хамаарч идэвхитэй хамтарч байгаа байдал ажиглагдсан. Мөн “сургалтаар заалгасан аргыг турших ёстой” гэж бодож байсан D багш хичээл заа гэхэд татгалзаж байсан боловч A багшийн “япон хэлний хичээлд хийх “хичээлийн судалгаа”-гаар багшийн заах аргыг үнэлэх бус сурагчийн сурах үйлд анхаарлаа хандуулж, сурах үйл явцыг таамаглан, өөрийн хичээлд дүн шинжилгээ хийж сайжруулах ёстой юм” хэмээн сэнхрүүлэхэд саналыг хүлээж авсан. Ингээд “хөөрч баярласан сурагчдыг анх удаа харсан” D багш бусад оролцогчдын саналыг анхааралтай сонсдог, өөрийн санаа бодлыг илэрхийлдэг, “хичээл үнэхээр хөгжилтэй сайхан байлаа” хэмээн өгүүлэх хэмжээнд хүрсэн. Өөрөөр хэлбэл “хичээлийн судалгаа” нь хичээл заасан D багшийн хувьд “бусад багш нарын өмнө шүүмжлүүлэх” талбар биш

болж сургагч багш А-гийн хувьд ч “багшийн заах аргыг шүүмжлэх, үнэлж дүгнэх” талбар биш болсон.

Гэвч D багшийн ярианд “багийн үйл ажиллагаанд карт ашиглах дасгал явуулахад карт бэлтгэхэд хүндрэлтэй байгаа тул дасгалыг анги нийтээр явуулах бодолтой байна” гэх мэт сурагчийн байр сууринаас бус багшийн байр сууринаас хандаж байгаа байдал анзаарагдсаар байна. Мөн бусад оролцогчдын дунд “өөрийн хичээл, заар аргаа эргэн харж дүгнэлт хийхийн тулд сурагчийн хандлага, сурч байгаа байдалд анхаарлаа хандуулах нь чухал юм” хэмээн ухамсарлаж байгаа хэдий ч багшийн байр суурь давамгайлах байдал ч илэрч байлаа. Сурагчийн байр суурийг ухамсарлаж, сурагчийн сурч байгаа байдлаас өөрийн зааж буй япон хэлний хичээлийг эргэн харах нь дунд Ява мужаас энэ туршилтанд оролцсон багш нарын нийтлэг бэрхшээл гэж үзэж байна.

5. Судалгааны ололт амжилт, тулгарсан бэрхшээл

Өмнөх бүлэгт судалгааны зорилгод нийцүүлэн тухайн мужийн нөхцөл байдалд тулгуурлан 1 мужийн туршилтын ололт амжилт, тулгарсан бэрхшээлийн талаар дурдсан. Харин энэ бүлэгт 6 мужийн туршилтанд оролцсон багш нараас авсан анкет судалгаанд үндэслэн нийтлэг ололт амжилт, тулгарсан бэрхшээлийн талаар өгүүлнэ.

Анкетын асуулга нээлттэй болон хаалттай (5 өгөгдөлтэй) асуулгын аргыг хослуулж хийгдсэн бөгөөд судалгаанд хамрагдсан хүний харьяалалын талаар 6 асуулга (Q1-Q6), энэ удаагийн туршилттай холбоотой 17 асуулга (Q7-Q23), япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”-ны туршилтын явцад болон туршилтын дараах судалгаанд хамрагдаж буй оролцогчтой холбоотой 7 асуулга (Q24-Q30, сэтгэгдэл, саналыг багтаасан)-аас бүрдсэн. Судалгаанд хамрагдаж буй оролцогчийн япон хэлний түвшинг харгалзаж анкетийг индонез хэлэнд хөрвүүлж, цахим шуудангаар илгээж, цахим шуудан болон шуудангаар бөглөсөн анкетаа цуглуулсан бөгөөд 54 оролцогчийн 53 нь уг анкет судалгаанд хамрагдав. Өгүүлэлийн хуудасны боломжоос хамаарч 7-29-р асуулгын үр дүнг хүснэгт 4-өөр үзүүлэв.

Хүснэгт 4 Анкет судалгааны үр дүн

Q	Асуулга	a	b	c	d	e
7	Энэ удаагийн туршилтаар хамтарч “маргаашийн хичээлийг сайжруулах”-ыг зорьсон учир миний ажиллах дур сонирхол нэмэгдсэн.	84.9	13.2	0.0	0.0	0.0
8	Энэ удаагийн туршилтанд оролцогч хийгээд бусад багш нартай хамтарч нэгж хичээлийн төлөвлөгөө зохиож чадна.	79.2	20.8	0.0	0.0	0.0
9	Энэ удаагийн туршилтанд оролцогч хийгээд бусад багш нартай үр дүнтэй заах аргын талаар ярилцаж чадна.	83.0	17.0	0.0	0.0	0.0
10	Энэ удаагийн туршилтанд оролцогч хийгээд бусад багш нартай хамтарч хэрэглэгдэхүүн боловсруулж, харилцан	56.6	43.4	0.0	0.0	0.0

	зээлж, зээлдүүлж хэрэглэж чадна.					
11	Энэ удаагийн туршилтанд оролцогч хийгээд бусад багш нарын ажиллаж буй сургууль дээр очиж хичээлд оролцох боломжтой.	56.6	39.6	0.0	0.0	0.0
12	Хариуцаж буй анги, ангийн сурагчдын талаар туршилтанд оролцогч хийгээд бусад багш нартай зөвлөж чадна.	73.6	26.4	0.0	0.0	0.0
13	Өдөр тутмын хичээлийн талаар туршилтанд оролцогч хийгээд бусад багш нартай зөвлөж чадна.	71.7	28.3	0.0	0.0	0.0
14	Энэ удаагийн туршилтанд оролцогчид бүгд ижил байр сууринаас санал дэвшүүлж хэлэлцэж чадсан.	69.8	28.3	1.9	0.0	0.0
15	Энэ удаагийн туршилтанд оролцогчдын дунд харилцаа үүсэхэд дэмжлэг үзүүлсэн.	54.7	45.3	0.0	0.0	0.0
16	Энэ удаагийн туршилтын явцад би аль болох сурагчийн байр сууринаас бодож чаддаг болсон.	49.1	51.0	0.0	0.0	0.0
17	Энэ удаагийн туршилтаар “Сурагчийн сурч байгаа байдал”-аас хичээлийг эргэн харж, шинжилж чадна.	75.5	22.7	0.0	1.9	0.0
18	Энэ удаагийн туршилтаар бүх оролцогчид хариуцлага хүлээж чадсан.	52.8	45.3	0.0	1.9	0.0
19	Энэ удаагийн туршилт нь сурагчдын сурах сэдэл тэмүүлэлд нөлөөлж чадсан.	64.2	34.0	0.0	1.9	0.0
20	Энэ удаагийн туршилт нь багшийн заах арга хийгээд хандлагыг өөрчилж чадсан.	64.2	24.5	1.9	5.7	1.9
21	Энэ удаагийн туршилт нь багш, сурагчийн суралцахуйн аз жаргал, баяр хөөрийг мэдрүүлж чадсан..	60.4	32.1	1.9	3.8	0.0
22	Энэ удаагийн туршилт нь сурагчдад чанартай япон хэлний хичээл заах эхний алхам болж чадсан.	47.2	51.0	0.0	0.0	1.9
23	Энэ удаагийн туршилт нь илүү сайн хичээл төлөвлөхөд оролцогчдод хэрэг болно.	66.0	34.0	0.0	0.0	0.0
24	Энэ удаагийн туршилтын явцад би өөрийн санаа бодлоо илэрхийлж чадсан. → санаа бодлоо илэрхийлж чадсан, чадаагүй шалтгаанаа тодорхой бичнэ үү.	34.0	62.3	0.0	3.8	0.0
25	Энэ удаагийн туршилтанд оролцсон нь үр дүнтэй байсан. →а, b хариулт сонгосон бол ямар эерэг үр дүн гарсаныг тодорхой бичнэ үү.	56.6	37.7	1.9	3.8	0.0
26	Энэ удаагийн туршилтанд оролцсоноор би өөрчлөгдсөн. →а, b хариулт сонгосон бол хэрхэн өөрчлөгдсөнийг тодорхой бичнэ үү.	54.7	39.6	3.8	0.0	0.0
27	Энэ удаагийн туршилтанд оролцсоноор би хичээлээ шинэчилж чадна. →а, b хариулт сонгосон бол хэрхэн шинэчлэхээр төлөвлөж байгаа тухайгаа тодорхой бичнэ үү.	50.9	39.6	3.8	3.8	0.0
28	Энэ удаагийн туршилтанд оролцсоноор танд ямар асуудал тулгарав. →а, b хариулт сонгосон бол ямар асуудал тулгарсан болохыг тодорхой бичнэ үү.	39.6	52.8	1.9	0.0	1.9
29	Би япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа”-г цаашид ч үргэлжлүүлэх бодолтой байгаа. → заавал хийнэ, хийнэ гэж бодохгүй байна гэж хариулсан бол шалтгаанаа бичнэ үү.	50.9	43.4	3.8	0.0	0.0

5.1 Багш нарын хамтын ажиллагаа

4-р хүснэгтийн 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 15, 18 гэсэн 10 асуулга “багш нарын хамтын ажиллагаа”-ны талаарх асуулга байв. “Q14: Энэ удаагийн туршилтанд оролцогчид бүгд ижил байр сууринаас санал дэвшүүлж хэлэлцэж чадсан.” гэсэн асуулгын хувьд судалгаанд оролцогчдын 69.8% нь “тийм” гэж хариулсан бөгөөд “бараг тийм” гэж хариулсан оролцогчидтой нийлээд 98.1% болж бараг бүх оролцогч эерэгээр үнэлж байв. 5 өгөгдөлтэй 7, 8, 9, 12, 13-р асуулгын хувьд ч үүнтэй ижил хандлага ажиглагдав.

“Q15: Энэ удаагийн туршилтанд оролцогчдын дунд харилцаа үүсэхэд дэмжлэг үзүүлсэн.” гэсэн асуулга хийгээд “Q18: Энэ удаагийн туршилтаар бүх оролцогчид хариуцлага хүлээж чадсан.” гэсэн асуулгын хувьд оролцогчдын 54.7%, 52.8% нь “тийм”, 45.3% нь “бараг тийм” гэж хариулсан бөгөөд дээрх 6 асуулгатай харьцуулахад эерэг хандлагад бага зэргийн ялгаа ажиглагдсан.

Ерөнхийдөө оролцогчид “багш нарын хамтын ажиллагаа”-г эерэгээр үнэлж байгаа боловч “бүх оролцогчид хариуцлага хүлээж чадсан” гэсэн асуулгатай санал нийлэхгүй байсан оролцогч байсныг үгүйсгэх аргагүй.

5.2 Хичээлийн шинэчлэл

Энэ удаагийн туршилтаар “сурагчийн байр суурийг ухамсарлах” нь том оролдлого байсан. “Q16: Энэ удаагийн туршилтын явцад би аль болох сурагчийн байр сууринаас бодож чаддаг болсон.” гэсэн асуулгад бүгд эерэг хариулт өгсөн боловч “Q17: Энэ удаагийн туршилтаар “Сурагчийн сурч байгаа байдал”-аас хичээлийг эргэн харж, шинжилж чадна.” гэсэн асуулгад цөөн тооны оролцогч “үгүй” гэж хариулсан байв.

Гэвч “Q19: Энэ удаагийн туршилт нь сурагчдын сурах сэдэл тэмүүлэлд нөлөөлж чадсан.” гэсэн асуулгад оролцогчдын 98.2% нь “яг тийм”, “тийм” гэж хариулсан бөгөөд үүнээс энэ удаагийн туршилт сурагчдад сайн нөлөө үзүүлсэн хэмээн дүгнэх боломжтой.

Түүнчлэн “хичээлийн шинэчлэл”-ийн хувьд авч үзвэл бүх оролцогчид “Q23: Энэ удаагийн туршилт нь илүү сайн хичээл төлөвлөхөд оролцогчдод хэрэг болно.” Гэж хариулсан байв. Нөгөө талаас “Q27: Энэ удаагийн туршилтанд оролцсоноор би хичээлээ шинэчилж чадна.” гэсэн асуулгын хариултаас өөрийнхөө заадаг хичээлд шинэчлэл хийж чадаагүй хэмээн хариулсан оролцогч байгаа гэдгийг ч мэдэх боломжтой. Мөн богино хугацааны туршилтын хязгаарлагдмал байдал, “хичээлийн судалгаа”-г тасралтгүй явуулсанаар даван туулах ёстой асуудлууд ч ил гарч ирсэн.

5.3 Туршилтын дараах асуудал

6 мужид 4 сарын турш үргэлжилсэн япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа” туршилтын тухай анкет судалгааны нээлттэй асуулга (Хүснэгт 4, Q24-

Q 29-р асуулга, Q30 санал, сэтгэгдэл)-д “Би ч, бусад багийн гишүүд ч энэ үйл ажиллагааг үр дүнтэй гэж үзсэн учир LS сургалт дууссаны дараа “хичээлийн судалгаа”-г үргэлжлүүлнэ.”, “Хот, мужийн багш нарын холбооны хэмжээнд “хичээлийн судалгаа”-г түгээн дэлгэрүүлмээр байна.” гэх мэт “хичээлийн судалгаа”-г тасралтгүй үргэлжлүүлэх хүсэл, үйл ажиллагааны хүрээг тэлэхийг хүссэн дуу хоолой ч байсан.

Мөн олон янзын хичээл, дасгалын аргыг эзэмших нь амжилтын нэг болохын зэрэгцээ “багийн үйл ажиллагаа сургалтыг илүү үр дүнтэй болгосон.”, “баг болж суралцсанаар сурагчид багшийн зааврыг хүлээхгүй, олон дасгал ажиллаж чаддаг болсон.” гэсэн хариултаас хариу үйлдэл бүхий тусгай үйл ажиллагааг бүх хүнд хүрсэн сайн арга хэмээн үзэж байгаа оролцогч байна гэж дүгнэж болно. Бид цорын ганц туйлын заар арга гэж байхгүй. Хичээлийн зорилго, анги, сурагчдын нөхцөл байдлыг сайтар судлаж мэдэхийн чухалыг тайлбарласаар ирсэн боловч бүх оролцогчид ойлгосон гэж хэлж чадахгүй. Энэ нь “хичээлийн судалгаа”-ны мөн чанартай холбоотой асуудал бөгөөд түүнийг бүрэн дүүрэн ойлгохгүй байвал цаашид хэлбэрийн төдий зүйл болж хяналтаа алдах аюултай. Тиймээс мөн чанарын талаарх ойлголтыг нэмэгдүүлэх, “хичээлийн судалгаа”-г цаашид үргэлжлүүлэхийн тулд туршилтанд оролцогчидтой харилцах, тэдэнд хандах аргыг эрэлхийлэх нь бидэнд тулгамдсан асуудал болоод байна.

6. Туршилтын дүгнэлт ба тулгамдсан асуудал

Дунд Ява мужид хийсэн туршилтын чанарыг задлан шинжилсэний үр дүнд D багш туршилтанд оролцсоноор үйл ажиллагааны зорилго, аргазүйг бусад оролцогчидтой сайтар ярилцаж хичээлийг хэрхэн өрнүүлэх талаар бодож боловсруулдаг болсон. Түүнээс гадна сурагчдын хариу үйлдлээс өөрийн аргазүйд дүгнэлт хийж хичээлийг сайжруулахад суралцаж, энэ нь сурагчдын сурах үйл явцад нөлөөлдөг болохыг ч ойлгосон тухай 4-р бүлэгт өгүүлсэн. Мөн энэ удаагийн туршилтын ололтыг оролцогчид “багш нар харилцан хамтран ажиллах”-снаар өөрөө өөрийгөө өөрчилж чадсанаас гадна заасан хичээл, аргазүйдээ дүгнэлт хийж “хичээлийг сайжруулах” төслийг бодож боловсруулсан. Түүнээс гадны сурагчдын сурахууд гарч буй өөрчлөлтийг анзаарсан зэргийг анкет судалгааны үр дүнд үндэслэн 5-р бүлэгт нэгтгэсэн.

Гэвч бид энэ удаагийн туршилт, орон нутгийн MGMP-гийн тусламж, дэмжлэгээс анкет судалгаанаас харж чадахгүй нэг асуудлыг олж харсан. “Хичээлийн судалгаа”-ны ерөнхий аргазүй гэж байдаггүй, зөвхөн тодорхой жишээг судлагдахуун болгож ямар нэг асуудалд төвлөрсөн судалгаа (Инагаки, Сато 1996:118) л байдаг. Иймд богино хугацаанд түүний жинхэнэ мөн чанарыг ойлгож чадахгүй. Тиймээс туршилтын явцад “хичээлийн судалгаа”-г багшийг үнэлэх талбар хэмээн ойлгох хүн ч байсан.

Мөн зөвхөн хичээл зааж буй багшид хариуцлага хүлээлгэхийг оролдож буй байдал, ахмад туршлагатай багш нараас “сурагчийн байр сууринаас бодож

үзвэл” гэсэн өмнөтгөлөөр эхлээд хичээл заасан залуу багшид зааж сургах гэсэн байдалтай ч нүүр тулсан. Үйл ажиллагааны жинхэнэ мөн чанарыг ойлгоё хэмээн эрмэлзэхгүй бол “багш нарын хамтын ажиллагаа” биелэлээ олохгүй. Цаашид тасралтгүй явуулахын тулд бид, туршилтанд оролцсон багш нар хэн хэн нь “хичээлийн судалгаа”-ны талаар илүү ихийг мэдэх шаардлагатай байна.

Дээр нь сургуулийг нуруундаа үүрч яваа багш нарын өдөр тутмын үйл ажиллагаанаас индонезид “хичээлийн судалгаа”-г тасралтгүй явуулахын тулд залуу багш нар ахмад багш нараас нэрэлхэж дөлөлгүй санаа бодлоо хэлэхэд анхаарах хэрэгтэй бөгөөд холбогдох нөхдүүдийн ойлголт ч зайлшгүй шаардлагатай байна. Учир нь маш завгүй байдаг ахлах сургуулийн багш цаг заваа зарцуулж хийлээ ч сургуулийн удирдлага, хамт олны ойлголт, дэмжлэг байхгүй бол үргэлжлүүлэх боломжгүй болох юм. Сургуулийн удирдлага, орон нутгийн боловсролын газраас ойлгож, хамтарч ажиллаж, туслаж дэмжвэл ойролцоо сургуулийн багш нар хамтран сурах талбар болгож “хичээлийн судалгаа”-г тасралтгүй явуулах, хөгжүүлэх боломжтой.

Түүнчлэн энэ удаа сурагчдаас судалгаа авч чадаагүй тул тэд туршилтыг хэрхэн хүлээж авсаныг мэдэж чадаагүй. Гэвч дунд Ява мужийн D багшийн жишээнд үндэслээд сурагчдын байр суурийг ухамсарлан хичээлийг шинэчилсэнээр сурагчдын сурах хүсэл эрмэлзэл, сонирхолд ахиц гарна хэмээн найдах боломжтой гэж үзэж байна.

2013 оны 8-р сард AGBJI-ын зохион байгуулсан LS сургалт япон хэлний хичээлд “хичээлийн судалгаа”-г турших хамтын талбар болж ICLS-тай хамтран ажилласны үр дүнд амжилттай дууслаа. Энэ үед шинэ сургалтын хөтөлбөрт “шавь төвтэй сургалт”, “хамтын сургалт”, “багаар ажиллах”, “шинжлэх ухааны аргагүй” гэх мэт түлхүүр ухагдахуун орсон бөгөөд тэдгээрийг хэрхэн хичээлийн туршилтанд буулгах вэ гэдэг нь холбогдох хүмүүсийн сонирхолыг ихэд татаж байна. MGMP-ийн удирдлаган дор цаашид үргэлжлэх “хичээлийн судалгаа”-ны хэлэлцүүлэг ч аяндаа “шинэ сургалтын хөтөлбөрийн агуулгыг тусгасан япон хэлний хичээл”-д чиглэж эхлэлээ.

21-р зууны мэдлэгийн нийгэмд шаардагдах хичээлийн шинэ агуулга, арга, “хичээлийн судалгаа” хийснээр багшийн мэргэжлийн чадвар нэмэгдвэл (Жийн, Акита 2008) цаашид япон хэлний хичээлийн “хичээлийн судалгаа” индонезийн дунд боловсролыг үүрч яваа багш нарын хүч хөдөлмөрөөр өөр өөрийн хөрсөнд буусан хэлбэрээр үндэслэж хамтдаа өсөж дэвжинэ гэдэгт итгэж байна.